



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/007

Арвайхээр

Биеийн тамир, спортын хамтлагийн
бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн "Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх тухай" 2010 оны 53 дугаар зарлиг, аймгийн Засаг даргын 2017 оны "Биеийн тамир, спортын хамтлаг байгуулах тухай" А/224 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх, оюун санаа, эрүүл мэндийг бэхжүүлэх, биеийн тамир, спортоор хичээллэх хэрэгцээг төлөвшүүлэх зорилгоор биеийн тамир, спортын хамтлагийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Хамтлагийн ахлагч: (Сумын Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: (Нийтийн биеийн тамир хариуцсан нийгмийн ажилтан)

Гишүүд: (Хотын Захирагчийн албаны Архитектор)
(Арвайхээр 5 дугаар багийн Засаг дарга)
(Зүлэгтийн 12 дугаар багийн Засаг дарга)
(Угтах үйлчилгээний ажилтан)
(Аж ахуйн нярав)

2. Биеийн тамир, спортын талаар гарсан төр, засгийн бодлого шийдвэрийг хамт олны дунд сурталчлан хэрэгжүүлэх, уралдаан, тэмцээн болон биеийн тамир, чийрэгжүүлэлтийн ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллахыг Биеийн тамир, спортын хамтлагийн ахлагч, Засаг даргын орлогч (Ц.Хоролсүрэн)-д үүрэг болгосугай.

3. "Хамтлаг байгуулах тухай" сумын Засаг даргын 2013 оны а/207 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.ПҮРЭВДОРЖ

371100213